



**ХЭНТИЙ АЙМГИЙН  
МӨРӨН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 09 сарын 13 өдөр

Дугаар 1/129

Мөрөн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 59 дүгээр зүйлийн 59.1.20 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын төсөвт байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийх, зөвлөн туслах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Г.Хишигбаатар Хууль эрх зүйн мэргэжилтэн

Гишүүд: Г.Загдхорол ХХЭА асуудал хариуцсан мэргэжилтэн

Ш.Баасандорж Байгаль орчны улсын байцаагч

Ж.Алтанцэцэг Татварын байцаагч

Д.Эрдэнэцэцэг Санхүү албаны дарга

2. Сумын төсөвт байгууллагын үйл ажиллагаанд хийх хяналт шалгалтыг 2024 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн дотор хийж үр дүнг Засаг даргын дэргэдэх Зөвлөлийн хуралд ажлын 5 хоногт багтаан танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (Г.Хишигбаатар)-т үүрэг болгосугай.

3. Төсөвт байгууллагуудын үйл ажиллагаа, албан баримт бичигт хяналт шалгалт хийхдээ хуульд заасан үндэслэл журмыг баримтлан ажиллахыг ажлын хэсгийн нийт гишүүдэд даалгасугай.

4. Ажлын хэсгийн хяналт шалгалт хийхээр шаардсан бичиг баримт, холбогдох албан тушаалтнуудыг бэлэн байлгахыг байгууллагын дарга, эрхлэгч нарт үүрэг болгосугай.

5. Хяналт шалгалтын удирдамжийг 2024 оны 09 дүгээр сарын 13-ний өдөр нийт төсөвт байгууллагуудад хүргэхийг ажлын хэсгийн ахлагч (Г.Хишигбаатар)-т даалгасугай

ДАРГА

Ц.БАТЦООЖ



C:\My Documents\ZAXIRAMZI.doc

234002129

Сумын Засаг даргын 2024 оны 09 дугаар  
сарын 13 өдрийн 1/18 тоот захирамжийн  
хавсралт

СУМЫН ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД  
ХЯНАЛТ, ШАЛГАЛТ ХИЙХ УДИРДАМЖ

**Зорилго:** Сумын төсөвт байгууллагад хяналт, шалгалт хийх, зөвлөн туслах.

**Хугацаа:** 2024 оны 09 дүгээр сарын 17-ны дотор

**Хамрах хүрээ:** Сумын Засаг даргын Тамгын газар, Ерөнхий боловсролын сургууль, Цэцэрлэг, Эрүүл мэндийн төв, Соёлын төв

**Хийх ажил:**

1. Байгууллагын Архивын стандарт, түүнд хөтлөгдөх баримт бичгийн бүрдлийг шалгах, зөвлөн туслах,
2. ХНУМТ цахим системийн хэрэгжилт, Khentii.mn сайтад үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээллийг тухай бүр оруулж байсан эсэх,
3. ЕБС, Цэцэрлэг, Эрүүл мэндийн төвийн хүнсний нөөцийн худалдан авалт, хадгалалтад хяналт шалгалт хийх,
4. Байгууллагын галын аюулгүй байдалд хяналт шалгалт хийх,
5. ERP цахим системийн ашиглалтад хяналт, шалгалт хийх,
6. ЕБС, Цэцэрлэгийн камерын бичлэг түүний хэвийн байдал болон зөрчилд хяналт шалгалт хийх
7. Хяналт шалгалтын үр дүнг, Засаг даргын зөвлөлд 5 хоногийн дотор танилцуулж, зөвлөмжийг байгууллагад хүргүүлнэ.